

# Азкабан

Гарри дайснууддаа дийлдэн Азкабан шоронд оржээ. Гэвч түүний найзууд хана нэвтрэхэд хэрэглэдэг эм дамжуулж чадсан тул түүнийг ашиглан шоронгоос оргох арга сэдэж буй. Азкабаны нийт талбай тэгш өнцөгт хэлбэртэй бөгөөд ижил хэмжээний квадрат хэлбэрийн өрөөнүүдэд хуваагдсан байна.  $M \times N$  ширхэг өрөөнүүд байгаа ( $M$  - ширхэг мөр, мөр бүрт  $N$  ширхэг өрөө). Гарри зүүн доод булангийн өрөөнд байгаа ба гарцтай ганц өрөө нь баруун дээд булангийн өрөө юм. Тэр шоронгоос гарахын тулд өөрийн өрөөний баруун дээд булангаас эхлэн гарцтай өрөөний зүүн доод буланг чиглэн шулуун алхана. Түүний хэдэн хана нэвт гарах ёстойг ол. Ямар нэг өрөөний буланг дайран гарахыг нэг хана нэвтэрлээ гэж үзнэ.

## Input

Өрөөнүүдийн тоог илэрхийлэх  $M, N$  натурал тоонууд өгөгдөнө ( $2 < M < 32000, 2 < N < 32000$ ).

## Output

Гарригийн нэвтлэх ёстой хананы тоог олно.

## Example

**Input:**

6 8

**Output:**

9

Жишээнд харгалзах зургийг доор үзүүлэв:

□